



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР



GRE Inc 201

ГЯНТБОЛД ОЛБОРЛОЛТ БА ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭГИЙН ТӨЛӨВ

2013 он



Судалгааны ажлыг боловсруулсан:

| | |
|---|--------------|
| АМГ, УУХ, НЭЗСТ-ийн дарга: | Б.Бямбадагва |
| АМГ, УУХ, НЭЗСТ -ийн ахлах мэргэжилтэн: | Ц.Цэгц |
| АМГ, УУХ, НЭЗСТ-ийн мэргэжилтэн: | Ч.Навчаа |

Судалгааны ажлын талаарх санал хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улс, Улаанбаатар 211238, Шуудангийн салбар 38,
АМГ, Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Баруун жигүүр, АМГ-ын байр Уул уурхай хэлтэс, НЭЗСТ

| | |
|-----------|---|
| Утас: | 976-11-263709 |
| Факс: | 976-11-310041 |
| E-mail: | navchaa68@yahoo.com |
| Web page: | http://www.mram.gov.mn |

ГАРЧИГ

1. Гянтболдын шинж чанар болон түүний хэрэглээ, ангилал
2. Дэлхийн гянтболдын олборлолт, нөөц болон хэрэглээний байдал
3. БНХАУ- н гянтболдын 2012-2013 оны зах зээлийн болон үнийн байдал
4. Гянтболдын олон улсын зах зээлийн байдал, 2012-2013 он
5. Монгол улсын гянтболд олборлолтын байдал
6. Монгол улсын гянтболдын гол илэрц ба ордууд
7. Үнийн хандлага, хэтийн төлөв
8. Дүгнэлт
9. Мэдээллийн эх сурвалж



1. Гянтболдын шинж чанар, түүний хэрэглээ, гол бүтээгдэхүүн

Гянтболд буюу вольфрам нь Химийн элементийн Менделеевийн үелэх системийн 74 дэх элемент бөгөөд химийн тэмдэг нь "W" билээ. Гянтболд нь бүх металлууд дотроос хамгийн өндөр хайлах температуртай металл бөгөөд түүний хайлах градус нь 3,244+-150 С байдаг. Энэ градууст бусад ихэнх металлууд Fe, Al, Cu, Ti нь аль хэдийн ууршин алга болдог. Гянтболын буцлах цэг (boiling point) буюу буцлах градус нь 5,7000С байдаг нь нарны гадаргын дулаантай адил болдог. Нягтшил нь 19,25г/см³ байдгаас харахад гянтболд нь хамгийн хүнд металлын тоонд ордог. Мөн бүх металлын дотроос хамгийн бага даралтад ууршдаг ба нягтшил, уян хатан чанар болон дулаан нэвтрэлтийг эсэргүүцэх өндөр чадвартай металл юм. Гянтболд нь дулаан ялгаруулалтын хэрэглээн дэх хамгийн чухал металл бөгөөд үүнд дулааны болон химийн тогтвортой байдал нь хамгийн гол нөлөө үзүүлдэг байна. Гянтболд нь гялгар цайвар цагаан өнгөтэй бөгөөд цэврээрээ байхдаа уян хатан шинж чанартай ба боловсруулалтад амархан ордог металл юм.

2005 онд International Union of Pure and Applied Chemistry гэсэн байгууллагаас вольфрам гэсэн нэрний оронд Гянтболд гэсэн нэршлийг хэрэглэх шийдвэр гаргасан ба химийн элементийн тэмдэг нь "W" хэвээр үлдсэн. Сүүлийн үед дэлхийн эдийн засгийн хөгжилд нөлөөлж байгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулахын тулд гангаар хийсэн өндөр хурдтай тоног төхөөрөмжүүдэд гянтболдын карбидыг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд үүнд гянтболдын орц чухал хувь нэмэр болж байна. Гянтболдыг гэрлийн технологи, цахилгаан хэрэгсэл, эрчим хүч, автомашин болон нисэх хүчний үйлдвэрлэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, өндөр градустай дулааныг бий болгоход төдийгүй мөн спорт болон гоёл чимэглэлийн салбарт ч хэрэглэж байна. Гэр ахуйн хүрээнд гянтболдыг цахилгаан гэрлийн шил, өдрийн гэрэл, эрчим хүч хэмнэгч төхөөрөмж, гар утас, телевиз, шарах шүүгээ гэх мэт бусад цахилгаан хэрэгслүүдийг үйлдвэрлэхэд өргөнөөр ашиглаж байна. Сүүлийн үед гянтболдын бактери болон энзимыг азот шингээгч бактеритай хамтад нь ургамал дээр туршиж хэрэглэн дэлхийн эртний түүхийг судлахад чухал хувь нэмэр оруулахыг олж тогтоосон байна.

Гянтболдын олборлолт ба баяжуулалт

Гянтболдыг голдуу гүний уурхайгаас олборлодог ба Шеелит (Scheelite) ба Вольфрамит (Wolframite) нь бага зэргийн хазайлттай нарийн судалд голдуу байрладаг бөгөөд гүн болох тусмаа энэ судал өргөсдөг байна. Гянтболдын ил уурхай байдаг ч их ховор тохиолддог. Гянтболдын хүдрийн уурхай нь харьцангуй жижиг байдаг бөгөөд өдөрт 2000 тн-оос илүү олборлодог уурхай ховор байдаг байна. Гянтболдын хүдрийг олборлох арга нь бусад металл олборлолтоос онц ялгаагүй бөгөөд голдуу хүдрийн ордын геологийн бүтцэд тохируулж олборлолтыг явуулдаг. Ихэнх Гянтболдын хүдэр нь 1,5%-аас бага WO₃-ыг агуулдаг. Нөгөө талаас авч үзэхэд олон улсад борлуулагдаж буй Гянтболдын баяжмал нь 65-75% -ийн WO₃-ыг агуулсан байх шаардлагатай байдаг тул Гянтболдтой хамт судалд бий болсон маш их хэмжээний эрдсийг тусад нь ялгаж тусгаарлах шаардлагатай болдог. Ийм учраас л хүдэр баяжуулах үйлдвэр нь тээвэрлэлтийн зардал хэмнэхийн тулд голдуу уурхайдаа маш ойрхон байрладаг. Гянтболдын хүдрийг эхэлж буталж нунтаглаад гянтболдын талстыг чөлөөлдөг ба Шеелитийн хүдрийг баяжуулахдаа гравиметрийн аргыг хөөст флотацийн аргатай хослуулан хэрэглэдэг бол вольфрамитийн хүдрийг баяжуулахдаа гравитацийн аргыг (спираль, конус, ширээний арга) соронзон аргаар ялгахтай хослуулан хэрэглэж байна.



Гянтболдын голлох бүтээгдэхүүний ангилал

1. Төмөрлөг Гянтболд (Ferro-Tungsten)

Төмөрлөг Гянтболд нь Гянтболд агуулсан гангийн бүтээгдэхүүнд шаардлагатай гол хайлш юм. Төмөрлөг Гянтболдын бүтээгдэхүүний гол түүхий эд нь Шеелит буюу Вольфрамитийн баяжсан буюу баян хүдэр юм. Мөн хиймэл (байгалийн бус) шеелитийн хаягдлыг ашиглаж болдог. Төмөрлөг Гянтболдын Вольфрамитийн агуулга нь 75-85% байдаг ба энэ нь саарал өнгөтэй, Fe_2W ба FeW –г агуулсан нунтаг бүтэцтэй. Төмөрлөг Гянтболдыг ихэвчлэн 80-100 микроны бүхэллэгтэйгээр нийлүүлдэг.

2. АРТ буюу Ammonium Paratungstate

АРТ буюу $(NH_4)(H_2W_{12}O_{42})4H_2O$ нь Гянтболдын бүтээгдэхүүнүүдээс хамгийн чухал анхдагч нь бөгөөд ихэнх хувийг нь эзэлдэг. Бусад бүтээгдэхүүн болох Гянтболдын гурван давхар исэл, Гянтболдын цэнхэр исэл, Гянтболдын исэл, Ammonium metatungstate –ийг бүгдийг нь химийн урвал юмуу дулааны задрал ашиглан АРТ-аас гаргаж авдаг. АРТ нь цагаан талсжсан нунтаг бөгөөд талстын дундаж хэмжээ нь 30-100 микрон. АРТ-чанарын үзүүлэлтэд хамгийн чухал нь хольцгүй цэвэр байдлын үзүүлэлт байдаг.

3. Гянтболд Карбидийн (WC) нунтаг

Гянтболд карбидын нунтаг нь Гянтболд болон карбидаас бүтдэг бөгөөд төрөл бүрийн түүхий эдээс янз бүрийн аргаар гаргаж авдаг. Түүний ихэнх хувийг нь гянтболдын нунтгаас карбюрацийн аргаар олон төрлийн ширхэглэлийн хэмжээтэйгээр гаргаж авдаг.

4. Гянтболдын нунтаг

Гянтболдын нунтагийг устөрөгчийн хэмжээг бууруулах аргаар гаргаж авдаг ба ширхэглэлийн дундаж хэмжээ нь 0,1-100 микрон байдаг. Энэ арга нь зарим талаараа их ашигтай. Учир нь энэ аргын бууруулах нөхцөлийг нь өөрчлөн гянтболдын нунтагийг хүссэн ширхэглэлийн хэмжээндээ гаргаж авах боломжийг бүрдүүлдэг. Гянтболдын нунтагийн ихэнх хэсгийг үйлдвэрлэлд өргөнөөр хэрэглэдэг.




2. ДЭЛХИЙН ГЯНТБОЛДЫН ОЛБОРЛОЛТ, НӨӨЦИЙН БОЛОН ХЭРЭГЛЭЭНИЙ БАЙДАЛ

Дэлхийн гянтболдын нөөцийн ихэнх хэсэг нь БНХАУ, ОХУ, Канад, АНУ-д зарим том ордууд Боливи, Португали, ОХУ –д байдаг.


Гянтболдын гол экспортлогч улсуудад нь: БНХАУ, Өмнөд Солонгос, Австри, гол импортлогч улсуудад : АНУ, Япон, Герман, Их Британи зэрэг улсууд ордог.

1-р зураг



Эх сурвалж: www.usgs.com

2-р зураг




Эх сурвалж: www.usgs.com

Гянтболдын гол хэрэглэгч улсууд

1-р хүснэгт

| | Япон | Европ | БНХАУ | ОХУ | АНУ |
|---------------------|------|-------|-------|-----|-----|
| Гянтболдын карбид | 67% | 72% | 54% | 70% | 66% |
| Нунтаг бүтээгдэхүүн | 11% | 8% | 11% | 4% | 20% |
| Ган/хайлш | 11% | 9% | 28% | 26% | 9% |
| Бусад | 11% | 11% | 7% | | 5% |

3-р зураг



3. БНХАУ-ын гянтболдын 2012-2013 оны зах зээлийн байдал, үнийн хандлага

Гянтболд нь ховор металлын нэг бөгөөд стратегийн чухал түүхий эдийн нэг юм. Дэлхийн гянтболдын нөөцийн 30%-г вольфрамит 70%-ийг шеелит эзэлдэг. БНХАУ нь Гянтболдын бүтээгдэхүүний гол үйлдвэрлэгч, экспортлогч улсын хувьд дэлхийн нийт нөөцийн 65%-ийг бүрдүүлдэг байна.

Гянтболд нь түүхий эдийн нөөцийн хувьд нилээд дээгүүр ордог бөгөөд тус улсад 252 орд илэрц бүртгэгдсэн байдаг ба нөөцийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж байна. АНУ ба Канад улс нь гянтболдын олборлолт ба үйлдвэрлэлээрээ БНХАУ-ын дараа орж байна. 65%-ийн агуулгатай WO₃-ын баяжмалыг Гянтболдын хүдрээс гаргаж авахдаа буталж шигшиж ялган дараа нь флотацийн болон соронзон аргаар ялгах аргыг нийтлэг ашигладаг.

4-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com


Гянтболдын баяжмалыг Төмөрлөг гянтболд (Ferro-tungsten) болон АРТ (Ammoniumparatungstate) – ийн гол түүхий эдийн хувьд вольфрамит ба шеелит гэсэн 2 ангилалд хуваадаг. Бусад орнуудад шеелитийн хүдэр Гянтболдын хүдэрт 60% -г эзэлдэг бол БНХАУ улс нь өнөөг хүртэл гянтболд агуулсан кварцийн судал дээр голлож олборлолт явуулдаг ба энэ нь БНХАУ-ын Гянтболдын хүдэр

олборлолтын 90%-ийг эзэлж байна.



Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр Гянтболдыг стратегийн чухал ач холбогдол бүхий түүхий эд болон эрсдэлтэй металлын тоонд оруулах болсон тул БНХАУ-ын засгийн газраас жил бүр Гянтболдын хүдэр олборлолтын хэмжээг тогтоож өгөх болсон ч олон уурхайнууд тогтоосон хэмжээнээс илүү олборлож байна. Иймд засгийн газар нь гянтболдын нөөцийг хамгаалж илүү олборлолтыг хязгаарлахын тулд цаашид нарийн арга хэмжээ авахаа мэдэгдсэн.

5-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

БНХАУ-ын Газар болон Нөөцийн яамнаас 2012 онд мужийн уурхайнуудад 2 үе шаттайгаар гянтболдын олборлолтын хэмжээг тогтоож өгсөн.


5-р зурагт үзүүлснээр БНХАУ-ын үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллийн дагуу 2012 онд нийтдээ 139928 тн гянтболдын баяжмал гаргасныг 2011 оны 134473 тн-той харьцуулахад 5455 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Европын өрийн хямрал болон дэлхийн эдийн засгийн тааламжгүй байдлаас шалтгаалан БНХАУ-ын дотоодын болон гадаадын зах зээл дээр гянтболдын хэрэглээ сул байлаа. Тус улсын гянтболдын зах зээл нь 2012 онд буурсан ба ялангуяа 2, 3-р улиралд илүү буурсан үзүүлэлттэй гарсан. 2012 оны 4-р улиралд үнийн хувьд бага зэрэг нэмэгдсэн ч арилжааны хэмжээ нэмэгдээгүй.

3.1 БНХАУ-ын зах зээл дэх 65%-ийн агуулгатай Гянтболдын баяжмалын үнийн байдал, 2012 он


6-р зураг

Гянтболдын баяжмалын үнийн хувьд БНХАУ-ын Гянтболдын Үйлдвэрийн холбооноос Guiding price буюу зах зээлийн баримжаа үнийг зарладаг ба 2012 онд зарлагдсан үнийг 6-р зурагт үзүүлээ



Эх сурвалж: www.asianmetal.com

7-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

Хаврын баярын амралт ойртож байсан 2012 оны 1-р сард ихэнх зах зээлийн оролцогчид гянтболдын арилжааны гэрээ хийхдээ идэвхгүй байснаас худалдааны гэрээ доогуур хэмжээнд байсан. 1 сарын дунд үе гэхэд 65%-н агуулгатай гянтболдын үнэ 137000 юань/тн (337 ам. доллар/10kg)-с 134000 юань/тн (330 ам. доллар/10kg) хүртэл буурсан. БНХАУ-ын гянтболдын зах зээлийн оролцогчид 1 сарын 21-ээс 2 сарын 6 хүртэл

Хаврын болон Дэнлүүний баярын амралт тохиолдуулан зах зээлийг орхисон ч зах зээл дээр арилжаа явагдаж байлаа. 2012 оны 2-р сарын эхээр ихэнх оролцогчид амралтаасаа буцаж ирэхэд зах зээл дээр нийлүүлэлт хомс байв. Тус оны 2-р сарын дундуур 65%-н агуулгатай гянтболдын үнэ 133000-135000 юань/тн (327-332 ам.доллар/10kg)-с 135000-137000 юань/тн(332-337 ам.доллар/10kg) болж нэмэгдсэн.

Гэсэн ч хэрэглээ нь сул байснаас 2-р сарын сүүлчээр үнэ нь дахин буурч дахин 133000-135000 юань/тн (327-332 ам.доллар/10kg) болсон. 3-р сард 65% агуулгатай Гянтболдын баяжмалын үнэ буурсаар 125000-127000 юань/тн буюу (308-313 ам.доллар/10kg) –д хүрсэн. 3-р сарын дундуур БНХАУ-ын өмнөд нутгуудаар бороо их орсноос Гянтболдын уурхайн олборлолт тогтмол явагдаагүйгээс Гянтболдын баяжмалын бүтээгдэхүүний хэмжээ буурсан. 3-р сарын сүүлчийн 2 долоо хоногт нийлүүлэлт бага байснаас шалтгаалан 65%-н агуулгатай гянтболдын баяжмалын үнэ 130000-132000 юань/тн-н хооронд тогтвортой байснаа хэрэглээний сул байдлаас болж үнэ нь дахин буурч эхэлсэн. 2012 оны 4-р сард Гянтболдын баяжмалын үнэ хэлбэлзэлтэй байсан. Энэ сарын эхний 7 хоногт үнэ нь 125000-127000 юань/тн-с буурч 123000-125000 юань/тн болсон ба дараагийн 2 долоо хоногт нь энэ үнэ тогтвортой байсан. Үнэ энэ хэмжээнд хүрэхэд ашгийн хэмжээ нь буурснаар ихэнх нийлүүлэгчид борлуулалтаа зогсоосон. Ингэснээр Гянтболдын баяжмалын үнэ 4-р сарын сүүлч гэхэд нэмэгдэж 125000-127000 юань/тн болсон. 5-р сарын эхнээс дунд үе хүртэл нийлүүлэлтийн хомсдлоос болж үнэ нь нэмэгдэж 131000-133000 юань/тн болсон. Зах зээл дээр нийлүүлэлт бага байсан нь үнийн өсөлтөд нөлөөлсөн. 5 сарын 2-р хагасаас зах зээлд оролцогчид нийлүүлэлтээ нэмэгдүүлснээр үнэ нь буурч 126000-127000 юань/тн болж энэ үнэ 6-р сарын дунд үе хүртэл тогтвортой байсан. Зах зээл дээр худалдан авалт хийгдэхгүй, хэрэглээ сул байгаагаас үнэ нь үргэжлэн буурсаар 6-р сарын сүүлч гэхэд 122000-124000 юань/тн болсон болсон ба зарим арилжааны үед үнэ нь 120000 юань/тн-с доогуур орох үе байсан.

2012 оны 7-р сард буурсаар сарын сүүлч гэхэд 108000-110000 юань/тн болсон. 8, 9-р сард гянтболдын зах зээл ямар нэгэн сэргэлт гараагүй ба үнэ нь буурч 104000-106000 юань/тн болсон.

10-р сарын эхний 7 хоногт БНХАУ-д баярын амралт тохиосноос зах зээл дээр




арилжаа маш бага явагдсан ба үнийн хувьд 105000-107000 юань/тн-н хооронд тогтвортой байсан бол 10 сарын 2-р хагаст нийлүүлэлт сул байснаас үнэ нь нэмэгдэж эхлэн 107000-109000 юань/тн болсон. 11 сарын Гянтболдын зах зээл сэргэж үнэ нь нэмэгдэж 65% агуулгатай Гянтболдын үнэ 118000-120000 юань/тн болсон ба сарын сүүлчээр хэрэглээний сул байдлаас шалтгаалан 116000-118000 юань/тн болж буурсан. 12 сард зарим компаниудын худалдан авалт нэмэгдэж эхэлснээр баяжмалын үнэ нэмэгдэж 118000-120000 юань/тн болсон ч хэрэглээ сул хэвээрээ байлаа.

2013 оны 3-р сараас Гянтболдын хэрэглээ нэмэгдэж үнэ тогтмол өссөөр байсан.

3.2 БНХАУ-ын зах зээл дэх АРТ-н үнэ, 2012-2013.08 (АРТ-Ammonium Paratungstate)

8-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

Ихэнх АРТ-үйлдвэрүүд 2012 оны 1-р сард бүтээгдэхүүн гаргалтаа зогсоож зах зээл нам гүм байсан. Хаврын баярын амралтаас шалтгаалан ихэнх хэрэглэгчид АРТ –г их хэмжээгээр нөөцлөхдөө болгоомжилж байсан. Гянтболдын баяжмалын үнэ буурахад АРТ-н үнэ бага зэрэг буурсан байна.

Хаврын амралтын өмнө үнэ нь 205000-


206000 юань/тн (371-373 ам.доллар/10кг)-н хооронд тогтвортой байсан. АРТ-ийн үнийн хандлага нь зах зээл дээр Гянтболдын баяжмалын үнийн хандлагыг дагаж өөрчлөгддөг. Баярын дараа АРТ үйлдвэрлэгчид захиалгын дагуу үйлдвэрлэлээ явуулж эхэлсэн ч 2-р сараас 4-р сар хүртэл үнэ нь 5,4%-р буурч 185000-187000 юань/тн (334-336 ам.доллар/10кг) болсон ба 4 сарын сүүлчээс эхлэн Гянтболдын баяжмалын үнэ нэмэгдсэнтэй уялдан 189000-191000 юань/тн (342-345 ам.доллар/10кг), 5 сард 198000-200000 юань/тн болтлоо нэмэгдсэн ч дахин буурч 194000-196000 юань/тн болсон. 6-р сард АРТ-ийн зах зээл сул хэвээрээ байсан ба хэрэглэгчид арилжаанд оролцоходоо идэвхгүй байсан. Иймд АРТ-ийн үйлдвэрүүд үйл ажиллагаагаа нэг нэгээрээ зогсоож эхэлсэн. 7-р сард борлуулалтын хэмжээ бага хэвээрээ байсан тул нилээд олон АРТ-ийн үйлдвэрүүд үйл ажиллагаагаа зогсоосон ба үнэ нь 166000-168000 юань/тн болтлоо буурсан. 8-р сард зах зээлийн байдал улам суларч сарын сүүлч гэхэд үнэ нь 160000-162000 юань/тн болж үргэлжлэн буурсаар байсан. 9-р сард АРТ- зах зээл дээр борлуулалт бага зэрэг хийгдэж байсан ч эдийн засгийн таагүй байдлын улмаас АРТ-ийн хэрэглэгчид нөөцөө нэмэгдүүлэх сонирхолгүй байсан. Ихэнх АРТ үйлдвэрлэгчдийн сарын бүтээгдэхүүний хэмжээ 50%-р буурсан ба хэрэглээний сул байдлаас шалтгаалан бүтээгдэхүүн гаргалт нь тогтмол хэмжээндээ гарахаа больсон. 10-р сарын сүүлч хүртэл үнэ нь бага зэргийн хэлбэлзэлтэй байсан ба 11 сарын эхний 3 долоо хоногт Гянтболдын баяжмалын үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор АРТ-н үнэ 178000-180000 юань/тн болж нэмэгдсэн. 12 сарын сүүлч гэхэд АРТ-ийн үнэ 172000-175000 юань/тн байсан ба сарын эхээр нэмэгдэж байсан АРТ-ийн захиалгын хэмжээ их нэмэгдээгүй. 2013 оны 3 сараас эхлэн дэлхийн гянтболдын зах зээл дээр худалдан авалт нэмэгдсэнээр 9 сар хүртэл Гянтболдын баяжмал болон бусад бүтээгдэхүүний үнэ нэмэгдсээр байна.



3.3 БНХАУ-ын зах зээл дэх 2012-2013 оны Гянтболдын карбидийн (цаашид WC гэж нэрлэнэ) нунтагийн үнийн байдал

Гянтболдын карбидийн зах зээлийн байдал нь эдийн засгийн байдлаас хамааран сул байсан ба хэрэглээ нь нэмэгдээгүй. БНХАУ-ын зах зээл дээр хэдэн арилжаа явагдаж байсан ч WC-ийн үнэ АРТ-ийн үнийг даган буурсан. 1-р сарын сүүлчээр дундаж хэмжээтэй WC-ийн үнэ 330-332 юань/кг (52.4-52.7 ам.доллар/кг) болж буурсан ба 2-р сард WC-ийн арилжаа нилээд хэдэн удаа хийгдсэн ба ихэнх үйлдвэрлэгчид захиалгат WC-аа нийлүүлэхийн тулд үйлдэрлэлийн нийт хүчин чадлынхаа 60%-аас бага хувийг ашиглах хэрэгтэй болсон. Энэ сарын эхэнд дундаж хэмжээтэй WC- үнэ 323-328 юань/кг (51.3-52.1 ам.доллар/кг) болж буурсан. Ихэнх хэрэглэгчид худалдан авах хэмжээгээ бууруулснаар 3-р сард WC-н зах зээлийн арилжааны явц удаашралтай байсан. Үйлдвэрлэгчдийн хувьд их хэмжээний нөөц хуримтлагдахаас зайлсхийн сарын бүтээгдэхүүний хэмжээг 40%-р бууруулсан. Дундаж хэмжээтэй WC-н үнэ нь түүхий эдийн үнэ буурсантай холбоотой үргэлжлэн буурсаар 4-р сард 300 юань/кг (47.5 ам.доллар/кг) болсон. Хэрэглэгчдийн хувьд WC –ийг ихээр дахин нөөцөлж байсан ба WC-ийн үнийн хандлагад АРТ –ийн үнийн өөрчлөлт шууд нөлөөлдөг учраас 5-р сарын эхэнд 303-308 юань/кг (47.9-48.7 ам.доллар/кг) байсан үнэ сарын дунд үе гэхэд нэмэгдэж 310-315 юань/кг (49.1-49.8 ам.доллар/кг) болсон. 6-р сарын сүүлч гэхэд үнэ нь 295-300 юань/кг (47.2-48.0 ам.доллар/кг) хүртэл буурч зах зээл нь сайжраагүй хэвээр байсан ба үйлдвэрлэгчид сарын бүтээгдэхүүний хэмжээгээ 50%-р бууруулж хэрэглээ нь үүнийг даган буурсан.

9-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

7-р сард үнэ нь буурсаар 270-275 юань/кг (42,7-43,4 ам.доллар/кг) болсон ба БНХАУ улсын дэд бүтцийн болон үл хөдлөх хөрөнгийн салбарын үйл ажиллагаа удааширнаас гянтболдын карбидын хэрэглээ буурсан. WC-ийн үнэ үргэлжлэн буурч дундаж хэмжээтэй WC-н үнэ 8-р сард 255-260 юань/кг(40,2-41.0 ам.доллар/кг), 9-р сард 252-257 юань/кг(40,3-

41.1 ам.доллар/кг), 10-р сард 250-255 юань/кг (40,0-40.8 ам.доллар/кг)-д хүрсэн. 11-12 сард хэрэглээ сул хэвээрээ байсан ба үнийн хувьд 270-275 юань/кг (42.9-43.7 ам.доллар/кг) орчим байсан.

3.4 БНХАУ улсын зах зээл дэх Төмөрлөг Гянтболдын (Ferrotungsten) үнийн байдал

БНХАУ-ын төмөрлөг Гянтболдын (FeW) зах зээл дээр хэрэглээ сул байснаас үнийн хувьд тогтмол буурсан үзүүлэлттэй байсан. Төмөрлөг Гянтболдын үнэ 2012 оны эхэнд 215000-220000 юань/тн (45.9-47.0 ам.доллар/кг W) байсан бол 2012 оны сүүлч гэхэд 180000-183000 юань/тн (38.4 -39.1 ам.доллар/кг W) хүртэл буурсан үзүүлэлттэй гарчээ. 2013 он гарсаар БНХАУ нь Гянтболдын баяжмал болон бүтээгдэхүүний нөөцөө нэмэгдүүлэхээ зарласнаар дотоодын зах зээл дээр үнэ нэмэгдэж энэ байдал дэлхийн зах зээл дэх үнэ нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн. Бусад Гянтболдын бүтээгдэхүүний адилаар




2013 оны 8-р сар хүртэл Гянтболдын карбид болон төмөрлөг гянтболдын үнэ өссөөр байна.

4. Гянтболдын олон улсын зах зээлийн байдал, 2012 он

4.1 АРТ (Ammonium paratungstate)

Европын АРТ-ийн зах зээлийн байдал 2012 оны 1 ба 2-р улиралд буурсан үзүүлэлттэй гарсан. Хэрэглэгчид нөөцөө нэмэгдүүлэхдээ болгоомжилж байснаас арилжааны хэмжээ бага байсан. АРТ-ийн үнэ 2012 оны 1-р сарын эхээр 425-430 ам.доллар/10кг байсан бол 5 сарын эхээр 360-370 ам.доллар/10кг болж буурсан. БНХАУ-д гянтболдын үнэ нэмэгдэж эхэлсэнтэй холбоотойгоор АРТ-ийн үнэ нэмэгдэж 5-р сарын сүүлч гэхэд 395-405 ам.доллар/кг болсон.

10-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

Зах зээл дэх ихэнх арилжаа нь урт хугацааны захиалгаас хамааралтай байсан ба цөөн арилжаа хийгдсэн үзүүлэлттэй байна. АРТ-ийн Европын зах зээл 2012 оны 3, 4-р улиралд сул хэвээрээ үргэлжилж үнийн хувьд ерөнхийдөө тогтвортой байсан. Хэрэглээний сул байдлаас шалтгаалан 2012 оны сүүлийн саруудад үнийн бууралт үргэлжилсээр 310-330 ам.доллар/10кг хүртэл буурсан байна.

4.2 Төмөрлөг Гянтболд (Ferrotungsten)

БНХАУ-ын төмөрлөг Гянтболдын зах зээл нь 2012 онд хэлбэлзэлтэй байлаа. Европын зах зээл дээр нийлүүлэлт бага байснаас 75% агуулгатай төмөрлөг Гянтболдын үнэ 2012 оны 1-р сард 47,75-48,3 ам.доллар/кг W, байсан бол 6 сар гэхэд нэмэгдэж 54,0-55,0 ам.доллар/кг W болсон. 6-р сард Европын зах зээл дэх төмөрлөг Гянтболдын гол хэрэглэгчид нөөцөө аажмаар нэмэгдүүлж эхэлсэн ба арилжааны хэмжээ бага зэрэг нэмэгдсэн. Үнийн хувьд 54,0-55,0 ам.доллар/кгW-н хооронд тогтвортой байсан. Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралтай байдлаас шалтгаалан төмөрлөг Гянтболдын хэрэглээ сэргэхгүй байснаас үнэ нь буурч 2012 оны 7 сард 53,4-54,4 ам.доллар/кг W байсан үнэ 2012 оны 11 сар гэхэд 43,2-44,5 ам.доллар/кг W болсон. Энэ үнийн байдал 12 сард тогтвортой байсан.

4.3 БНХАУ-ын импортын байдал, 2012 он

БНХАУ нь 2012 онд нийтдээ 9294,321 тн Гянтболдын баяжмал импортоор оруулсан ба үүний 3158,85 тн-г орос улсаас нийлүүлсэн нь нийт импортын 34%-г эзэлж



байна. Тус улсад Гянтболдын баяжмал нийлүүлэлтээрээ Канад улс 2-р байранд орж байгаа бөгөөд 2012 онд 1789,12 тн-г нийлүүлсэн нь БНХАУ-ын нийт импортын 21%-г эзэлсэн. Монгол улсын хувьд 2012 онд 591,244 тн Гянтболдын баяжмал нийлүүлсэн үзүүлэлттэй байна. Гянтболдын 2012 оны импортын хэмжээг 2-р хүснэгтэд үзүүлсэн.

БНХАУ-ын гянтболдын баяжмалын импортын хэмжээ, 2012 он


2-р хүснэгт

| Улс | 2012.01 | 2012.02 | 2012.03 | 2012.04 | 2012.05 | 2012.06 | 2012.07 | 2012.08 | 2012.09 | 2012.10 | 2012.11 | 2012.12 | Нийт (кг) |
|--------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|---------|-----------|
| Монгол | 176316 | | 124608 | | | 22280 | | 44828 | 26328 | 91324 | 59050 | 46600 | 591244 |
| Канад | 107246 | 289112 | 171688 | 171776 | 192938 | 150230 | 128402 | 128682 | 171243 | 128500 | 179796 | | 1789613 |
| Орос | 96892 | 378051 | 240576 | 217375 | 260602 | 179036 | 358897 | 180586 | 200387 | 239732 | 380781 | 425943 | 3158858 |

4.4 БНХАУ-ын экспортын байдал 2012 оны

БНХАУ улсын сангийн яамны мэдээллээс харахад 2012 онд 15400 тн гянтболдыг экспортод гаргасан бөгөөд энэ хэмжээг урьд оны мөн үетэй харьцуулахад 300 тн-оор доогуур буюу 1,91%-р буурсан үзүүлэлттэй гарсан.

11-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

4.4.1 БНХАУ-ын 2012 оны АРТ-ийн экспорт

БНХАУ улс нь 2011 онд 5136,18тн АРТ экспортод гаргаж байсан бол 2012 онд 2464,4 тн АРТ гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2671,78тн-оор буурсан үзүүлэлттэй байна. Голланд, АНУ, Япон зэрэг улсууд нь АРТ-ийн гол хэрэглэгч улсууд бөгөөд 2012 онд эдгээр улсуудын нийт АРТ худалдан авалтын хэмжээ нь 2096,4 тн хүрсэн нь нийт БНХАУ улсын экспортын 78%-ийг эзэлж байна.



12-р зураг




Эх сурвалж: www.asianmetal.com

13-р зураг

4.4.2 Гянтболдын исэл -УТО (Tungsten Oxide)

Б Н Х А У - ы н Гянтболдын ислийн эксортын хэмжээ 2012 онд 5155,965 тн байсан ба 2011 оны хэмжээтэй харьцуулахад 5,8% буюу 323,4 тн-р буурсан. Тус улсаас Гянтболдын ислийг импортлогч гол улсуудын тоонд Япон, Өмнөд Солонгос, Швед, АНУ зэрэг улсууд орж байна.



Эх сурвалж: www.asianmetal.com

14-р зураг




Эх сурвалж: www.asianmetal.com



4.4.3 Устөрөгчит Гянтболдын исэл- ВТО (Hydrogen Tungsten Oxide)

БНХАУ-ын Устөрөгчит Гянтболдын ислийн эксортын хэмжээ 2012 онд 6204,6 тн болсон ба 2011 оны экспортын хэмжээтэй харьцуулахад 26,2% буюу 2198,44 тн-р буурсан үзүүлэлттэй байна. БНХАУ-аас Устөрөгчит Гянтболдын ислийг импортлогч гол орнуудад Өмнөд Солонгос, Канад, Нидерланд, АНУ зэрэг улсууд орж байна.

15-р зураг



Эх сурвалж: www.asianmetal.com

5. МОНГОЛ УЛСЫН ГЯНТБОЛД ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ

Энэ металлыг бүр эрт XIII зууны үед манай өвөг дээдэс хэрэглэж байжээ. Монголчууд одоогийн Налайх дүүргийн орчимд тухайн үедээ Баян модны уурхай гэх газар гянтболдыг гарган авч, өөр бусад гантай хольж хат сайтай, бат бөх гянтболдоор илд хийдэг байж.

Монгол оронд Ардын хувьсгал ялсны дараахан буюу 1922 оны 12 дугаар сарын 25-нд шинэ тулгар Ардын Засгаас Налайхын нүүрсний уурхайг улсын болгох шийдвэр гаргаснаар уул уурхайн суурь тавигдсан байна. Үүнээс өмнө ч Монголд уул уурхайн үйлдвэрлэл явуулж байсан түүх бий.

1922 оны Ардын Засгийн шийдвэрийн дараа гарсан бас нэг томоохон үйл явдал бол 1940 оны сүүлчээр Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэг байгуулагдсан нь Дэлхийн II дайнтай холбоотойгоор ЗХУ-д гянтболд, молибдени зэрэг ховор металлын хэрэглээ нэмэгдсэн. Монголын төв болон дорнод хэсэгт өнгөт, ховор металлын хайгуул, ашиглалт явуулах ЗХУ-ын Хүнд металлын үйлдвэрийн яамны Дөрөвдүгээр тусгай экспедицийг байгуулсан нь Чоноголын гянтболдын орд газрын хайгуулыг хийж, улмаар 1942 оноос ашиглаж эхэлсэн байдаг. Дараа нь Түмэнцогт, Бүрэнцогтын ордуудыг хайн олж, ашиглах болсон байна.

Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Совмонголметалл” нийгэмлэгийг байгуулах хэлэлцээрт 1949 оны 3 дугаар сарын 12-нд хоёр тал гарын үсэг зуржээ. Нийгэмлэгийн бүрэлдэхүүн: Монголын нутаг дэвсгэрт хайгуул хийж: Чоногол, Түмэнцогт, Чулуун хороотын гянтболд, Модотын цагаан тугалга, Дожир, Ямаат, Бэрхийн хайлуур жоншны уурхайнуудыг ашиглан ажиллаж, бүтээгдэхүүнээ Зөвлөлт рүү гаргаж байсан ба гянтболдыг эх орны дайны үед Оросууд зэр зэвсэг үйлдвэрлэхэд ашиглаж байсан.

“Совмонголметалл” нийгэмлэг 1949-1957 оны хооронд ажилласан ба 1957 он гэхэд уг нийгэмлэгийг Монголын талд бүрэн шилжүүлэх ЗХУ-ын саналыг зөвшөөрч, 1960 он гэхэд зөвлөлтийн мэргэжилтнүүд нутаг буцаж дуусжээ.



1960 оны эхэн үе бол Монгол улсад геологийн судалгаа шинжилгээний ажил эрчимтэй хөгжөөгүй, улс орны газрын баялаг болох ашигт малтмалын орд илрэлүүд бараг хөндөгдөөгүй шахам байсан ч 1950-1960 онуудад Чулуун Хороот, Чоногол, Түмэнцогт, Модот, Их Хайрхан Бүрэнцогтын гянтболдын уурхайг ажиллуулж, сорьцчилсон олборлолтууд хийж байжээ.

1962 онд Их Хайрханы хайгуулын ангийн Улаануудын районд уртаараа 170 м гянтболдын эрдэсжилт бүхий судлыг олж, мөн 40 метрийн 3 блок тогтоон ашиглаж, 1965 онд дууссан болно. Онгон хайрханд гянтболдын судал хэлбэрт илрэлийн зэрэгцээ хүдрийн биет илэрч том орд болох төлөв тогтоогдсон. Чоно голын гянтболд ордын судал хэлбэрт хүдрийн биетийн доод хэсэгт боржингийн цулын дээд хэсэгтээ кварцаар хучигдсан б гянтболдын хүдэржилт тогтоогджээ. Олон улс оронтой хоёр талын хамтарсан хайгуулын ажиллагааг явуулсны үр дүнд: Нарантолгой, Сүжигт, Зуун мод, Хар ямаатын алтны ордууд, Салаа /W/, Арын нуур /Mo/, Салхитын /Zn/ орд, Өндөр цагаан /W, Mo, Zn, Pb, Ag/, Хужиханы /Sn/, Тавантолгойн гөлтгөнө, галд тэсвэртэй тоосгоны шавар, Чулуут цагаан дэлийн /CaF₂/ зэрэг ордууд ашигт малтмалын олон илрэлүүд тогтоогдсон, бөгөөд одоо ч зарим нь судалгааны хэмжээнд байсаар байна.

Монгол улсын геологи уул уурхайн салбар нь хамгийн өндөр хурдацтай хөгжиж байсан үе бол 1960-1990 он болно.

Монгол улсад гянтболдын : Чоногол, Их хайрхан, Салаа, Чулуун хороот, Цагаан даваа, Бүрэнцогт, Өндөр цагаан, Онгон хайрхан, Югүзэр, Өвөр баян, Ар баян, Нарангийн гол, Нуурын гол, Сагсай, Салаа, Түмэнцогт, Цагаан нуур, Хар чулуут, Шар хад, Халгай, Улаан-үд зэрэг 20-оод орд илрэлүүд нээгдэж тогтоогдсон Үүнээс: Төв аймгийн Баянчандмань суманд “Мон вольфрам” монгол компани үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

6. Монгол улсын гянтболдын гол илэрц ба ордууд

1. Баяндавааны цагаан тугалга, гянтболдын бүлэг орд

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Баяндавааны цагаан тугалга, гянтболдын бүлэг орд нь нийслэлд хамгийн ойр ордын нэг. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн энэ ордыг одоогоор ашиглаагүй байна.

Ордын хувьд тийм ч их нөөцтэй бишээс гадна ашиглах боломж багатай гэж салбарынхан үздэг. Баяндавааны бүлэг ордод чухам ямар ордыг хамруулж байгаа нь тодорхойгүй учир ирээдүйд будлиан гарах магадлал их бий гэдэг. Яагаад гэвэл, Төв аймгийн Эрдэнэ сумын Баяндаваагаар давсан засмал замын дэргэд байрладаг ба Баяндаваа, Баян, Өндөр, Хөхт гэсэн дөрвөн жалганд байгаа 500 тн ч хүрэхгүй бага нөөцтэй жижиг орд юм.

2. Улаан-Уулын цагаан тугалга, гянтболдын орд

Улаан-Уулын гянтболдын орд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт оршино. 1980 онд Улаан уулын гянтболдын ордын хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийжээ. Тухайн үед ордын нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр 16 дугаар судалд С1 зэргээр 8,2 мян.тн, С2 зэргээр 18,36 мян.тн, 32 дугаар судалд С1 зэргээр 5,75 мян.тн, 9 дүгээр судалд С2 зэргээр 17,51 мян.тн, 8 дугаар судалд С2 зэргээр 10,32 мян.тн, 7 дугаар судалд С2-4,52 мян.тн нийтдээ 63 000 тн гэж тогтоосон байна. Талбайн хэмжээ 37.51 га. Урьд нь нөөц тогтоогдон хайгуул, ашиглалт эрхэлж байсан энэ ордод одоо бага хэмжээний ашиглалт явуулж байгаа. “Кайнар Вольфрам” компани ажиллуулж, бүтээгдэхүүнээ гадаадад гаргаж байгаа аж.



Хүдрийн биетүүд нь Баруун (судал1-33), Кызыл Таугийн (34-39), Зүүн урд (40-59) гэсэн гурван хүдрийн бүсэд оршино. Баруун бүсэд 33 судлыг ялгасан ба тэр нь 300-800 м хүртэл урттай, 0,4-2,0 м хүртэл зузаантай болно. Ордын гянтын гол хүдэр болох вольфрамит бор улаанаас хар хүртэл өнгийн, хавтанлаг хэлбэрийн талст байдалтайгаар 0.5-3.5% хүртэл агуулгатайгаар судлуудад тохиолдохоос гадна түүнтэй хамт бага хэмжээний мусковитын хайрс, магнетитын жижиг талст, мөн 0,1 мм хүртэл хэмжээний шигтгээ алт, висмутин, халькопирит, базовисмут зэрэг хүдрийн эрдсүүд ховорхон ажиглагддаг байна. Мөн висмут, берилл, ниобийн агуулга 0,001-0,01% юм байна.

3. Баяндавааны цагаан тугалга, гянтболдын бүлэг орд

Жанчивлангийн цагаан тугалга, гянтболдын бүлэг орд нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Жанчивлангийн рашаанаас баруун урагшаа 2-3 км-т байрладаг. Цагаан тугалга, гянтболдын энэхүү шороон ордын хайгуулыг улсын төсвийн хөрөнгөөр хийсэн бөгөөд одоогоор ашиглаагүй байгаа. Рашаан сувилалд ойрхон учир ашиглахад хүндрэлтэй гэж үздэг байна.


4. Цагаан давааны цагаан тугалга, гянтболдын

Цагаан давааны цагаан тугалга, гянтболдын орд Улаанбаатар хотоос 76 км-т буюу Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрт байрладаг. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн энэ ордыг одоо бага хэмжээгээр ашиглаж байгаа. Гянтболдын баяжмал үйлдвэрлэх бага оврын хүдэр боловсруулах үйлдвэр, тоосгоны үйлдвэр зэрэг барилга байгууламжаас бүрдсэн жижгэвтэр уул уурхайн цогцолборыг 1989 онд анх Унгарын Засгийн газраас олгосон техникийн туслалцааны үндсэн дээр байгуулжээ.

Цагаандавааны гянтболдын гүний уурхайг одоо "Mon Wolfram" компани ажиллуулж байна. "Mon Wolfram" нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг цөөн тооны гянтболд олборлогч компанийн нэг юм. Цагаандавааны ордын нийт батлагдсан нөөц нь В+С1-2435 тонн, С2-686 тонн юм. Гянтболдын уурхай бүрэн хүчин чадлаараа жилд 500 тонн баяжмал гаргах ёстой. Гэвч техник, эдийн засгийн байдлаас болж жилдээ 68 хувийн WO₃-ын агуулгатай 30-50 тонн баяжмал олборлож, түүнийгээ АНУ, БНХАУ руу гаргадаг байна.

"Mon Wolfram" компани ордын дэргэдэх талбайдаа дагалдах орд нээх замаар нөөцөө нэмэгдүүлэх магадлал өндөр байгаа тул хайгуулын ажил хийхээр төлөвлөж байгаа. Тус компани хайгуул хийх 142 гектар газартай бөгөөд энэ нь гол төлөв одоо ашиглаж буй ордын дэргэдэх орчинд байрладаг.

16-р зураг



Эх сурвалж: АМГ.НЭЭСТ-ийн мэдээлэл

Монгол улсын сүүлийн 8 жилийн гянтболдыг олборлолтын байдлыг 16-р зурагт үзүүлээ. Үүнээс харахад Монгол улсын гянтболдын олборлолт 2007 оноос хойш буурсан үзүүлэлттэй байгаа ч сүүлийн 3 жилийн байдлаар олборлолт болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь нэмэгдсэн үзүүлэлтэй байна.



7. ҮНИЙН ХАНДЛАГА

БНХАУ-ын улсын гянтболдын баяжмал болон бүтээгдэхүүний үнэ нь дэлхийн зах зээл дэх үнийн түвшний хэмжүүр болдог ба тус улс өөрөө гянтболдын завсрын болон гүн боловсруулсан бүтээгдэхүүн болох гянтболдын карбид, металл нунтагийн үндсэн хэрэглэгч ба нийлүүлэгч нь болж байдаг. БНХАУ нь дэлхийн зах зээл дээр гянтболдын баяжмал нийлүүлэхгүйгээр бүтээгдэхүүн болгож экспортод гаргадаг ч гянтболдын баяжмалын дотоодын зах зээлийн үнэ нь дэлхийн зах зээл дэх үнийн гол чиглүүлэгч болдог.

Гянтболдын баяжмалын 2013 оны эхний 9 сарын дундаж үнэ 132584,71 юань/тн-г 2012 оны мөн үеийн үнэ болох 122852,14 юань/тн-тай харьцуулахад харьцуулахад 7,92%-р нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Гянтболдын хүдэр ба баяжмалын үнэ 2013 оны 3-4 сараас эхлэн 8 сар хүртэл тогтмол нэмэгдэж байгаа ба үүнд зарим компаниуд гянтболдын баяжмалыг харьцангуй их хэмжээгээр худалдан авч байгаагаас зах зээл дээр үнэ нь өсөх хандлагыг бий болгосон. Гянтболдын баяжмалын үнэ нэмэгдэж байгаагаас АРТ-ийн үнэ нэмэгдэж 183000-186000 юань/тн буюу 331-336 ам.доллар/тн-д хүрч байна. Сүүлийн үед БНХАУ улсын Гянтболдын зах зээл сэргэж байгаа бөгөөд Гянтболд энэ онд үнэ нь нэмэгдэж буй ганц түүхий эд болсон ба дунд ба урт хугацаанд Гянтболдын баяжмал болон бусад бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх хандлагатай байна. 3-р хүснэгтэд 2013 оны гянтболдын баяжмалын үнийн өөрчлөлтийг улирлын байдлаар харьцуулан үзүүлээ.

3-р хүснэгт

| 2013он | Дундаж үнэ, юань/тн | Харьцуулалт | Өөрчлөлт |
|------------|---------------------|-------------|----------|
| I улирал | 114476.03 | | |
| II улирал | 133650.36 | III/I | 17% |
| III улирал | 149627.74 | III/II | 11.95% |

17-р зураг



8. ДУГНЭЛТ

БНХАУ-н болон олон улсын Гянтболдын зах зээл үнийн хувьд 2013 оны эхний 3 улиралд өсч буурсан үзүүлэлттэй байлаа. Учир нь 3-р сараас эхлэн 8-р сар хүртэл нэмэгдэж байсан гянтболдын үнэ худалдан авалт бага байгаагаас шалтгаалан 8-р сарын 2-р хагас болон 9-р сард буурсан. Энэ оны 4-р улирлаас эхлэн үнэ нь нэмэгдэж байгаа ба үүнд БНХАУ-ын China Minmetals нь Гянтболдын баяжмал худалдан авалтаа үргэлжлүүлж дахин нөөцөлж эхэлсэн нь гол нөлөө үзүүлсэн.

БНХАУ улсын нөөцийн хорооноос Гянтболдын баяжмалыг 10000 тн худалдаж авч нөөцлөхөө 2013 оны эхээр зарласан. Тус улсын статистикийн газрын мэдээллээр 2003-2011 оны хооронд гянтболдын хүдрийн нөөц нь 4,2 сая.тн-оос 1,9 сая.тн хүртлээ буурсан нь нөөцийг нэмэгдүүлэх гол шалтгаан болсон. Иймд дунд болон урт хугацаандаа гянтболдын баяжмал болон бүтээгдэхүүний эрэлт хэрэглээ гангийн хайлш бэлтгэхэд болон дэвшилтэт техник технологийн салбарт нэмэгдэнэ. Ирэх жилүүдэд хэрэглээгээ даган Гянтболдын баяжмал болон бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх хандлагатай байгаа ба 21-р зурагт 65%ийн агуулгатай Гянтболдын үнийн таамаглалыг үзүүлээ. Гянтболдын баяжмалын үнэ нь бусад гянтболд агуулсан бүтээгдэхүүний үнийн байдалд гол нөлөө үзүүлдэг.

18-р зураг

Монгол улсын хувьд Гянтболдын хэрэглээ дэлхийн зах зээл дээр ихээр нэмэгдэж буй энэ үед гянтболдын орд газруудын нөөцийг тодорхой тогтоож, орчин үеийн техник технологи ашиглан хаягдалгүй олборлох, орчин үеийн тоног төхөөрөмжтэй лаборатори байгуулах зэрэг асуудалд нэн тэргүүнд анхаарах хэрэгтэй байна. Иймээс

цаашид хэрэглээ болон үнэ нь нэмэгдэх хандлагатай байгаа гянтболдын томоохон орд газрын ойролцоо орчин үеийн техник технологитой гянтболдыг ялгаж эцсийн бүтээгдэхүүн цаашидаа гаргах үйлдвэр байгуулах нь эдийн засгийн үр ашигтай.



9. Мэдээллийн эх сурвалж

Ч.Маамхүү, Зөвлөх инженер, Минералогич, “ШУТ-ийн Гянтболдын хүдрийн судалгаа”-ны материалаас, ЭБТХ

- www.metaleconomics.com
- www.metalprices.com
- www.usgs.commodity
- www.asianmetal.com
- www.steelindex.com



GRE Inc 20

